



► Практик Удирдамж

Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг сэргээн ажиллуулахад анхаарах арван арга хэмжээⁱ

КОВИД-19 өвчний халдвараас урьдчилан сэргийлэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг сэргээхэд ажил олгогч, ажилтан тэдгээрийн төлөөлөгчдөд зөвлөмж өгөхөд энэхүү удирдамж чиглэж байна.ⁱⁱ

Энэхүү удирдамж нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдэлийн менежментийнⁱⁱⁱ талаар ОУХБ-аас батлагдсан зарчим, аргачлалд суурилсан бөгөөд ажилчдын оролцоог хангахыг уриалж байна. Энэхүү удирдамжийг үндэсний хэмжээнд мөрдөж буй заавар, зөвлөмжтэй нийцүүлэх шаардлагатай бөгөөд эрүүл мэндийн үйлчилгээ зэрэг эрсдэл өндөртэй салбарт чиглэгдээгүй юм.

► 1: АЖИЛДАА БУЦАЖ ОРОХ АЖЛЫГ ТӨЛӨВЛӨН, ЗОХИОН БАЙГУУЛАХ ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ ХАМТАРСАН БАГ ТОМИЛОХ

- Аж ахуйн нэгж, байгууллагууд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлөө хуралдуулах шаардлагатай. Хэрэв ийм бүтэц байхгүй, цөөн ажилтантай бол ажил олгогчийн шийдвэрээр ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтан болон ажилтан, ажил олгогчийн ижил тооны төлөөллийг оролцуулсан хамтарсан багийг томилох нь зүйтэй.
- Ажлын байранд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үндсэн зарчмуудад багийн гишүүдийг сургана.
- Томилогдсон баг нь ажилтнуудыг ажилдаа буцаж ороход ажлын байрыг эрүүл, аюулгүй байлгахад чиглэсэн шаардлагатай арга хэмжээг багтаасан ажлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлнэ.
- Байгууллагын нийт ажилтнуудад энэхүү баг болон түүний хийж хэрэгжүүлж буй ажлын талаар тодорхой мэдээлнэ.

► 2: ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ХЭЗЭЭ ЭХЛҮҮЛЭХ, ЯАЖ АЖИЛЛАХ, ХЭН ИРЖ АЖИЛЛАХ ТАЛААР ШИЙДЭХ

- Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг сэргээхэд шаардлагатай урьдчилан сэргийлэх, хяналт тавих арга хэмжээг тодорхойлохын тулд эрсдэлийн үнэлгээ^{iv} зайлшгүй хийнэ. Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг сэргээхээс өмнө урьдчилан сэргийлэх болон хяналт тавих арга хэмжээг авсан эсэхийг нягталж баталгаажуулна (анхаарах дараагийн арга хэмжээг харна уу).
- Ажлын байран дахь ажилтнууд болон зочдын тооноос хамаарч бодлого, үйл ажиллагааг тогтооно.
- Боломжтой бол үйл ажиллагааг эхлүүлэхдээ хамгийн бага түвшнээс хэвийн түвшин хүртэл үе шаттай шилжихээр арга хэмжээгээ төлөвлөнө. Үйл ажиллагааг үе шаттайгаар эхлүүлэхдээ ажлын байран дээр зайлшгүй байх ажилтнуудын тоо, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах, хэрэгжүүлэхэд хяналт тавих гол цэгүүдийг тодорхойлно.

▶ 3: ИНЖЕНЕРЧЛЭЛ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, УДИРДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ АВАХ

- КОВИД-19 өвчин халдварлахаас сэргийлж инженер, зохион байгуулалт, удирдлагад чиглэсэн хяналтын-шаталсан стратеги арга хэмжээ авах хэрэгтэй.

Бие махбодоор хүрэлцэхээс зайлсхийх

- Зайнаас болон цахимаар ажиллахыг аль болох дэмжих.
- Ажлын байранд хүн хоорондын зайг 2 метрээс багагүй байлгах.
- Нэг ажлын байр, талбайд ажиллаж буй ажилтнууд хооронд болон гуравдагч этгээд, үйлчлүүлэгч, ханган нийлүүлэгч, хэрэглэгч хооронд бие махбодын тусгаарлалтыг хангах зорилгоор хаалт, тусгаарлалт суурилуулах.
- Хүн хоорондын зайг барихын тулд ажлын байрны бүхий л газрын (уулзалтын өрөө, оффис, семинар, хоолны өрөө, лифт, угаалгын өрөө, хувцас солих өрөө болон бусад нийтийн зай талбай) боломжит дээд хэмжээг тодорхойлж, сануулга, тэмдэг байршуулах.

Агааржуулалт

- Ажлын байрыг өдөр бүр агааржуулах, аль болох цонх, салхивч нээх зэргээр байгалийн аргаар агааржуулах
- Ээлжийн ажлын хувьд ээлж бүрийн хооронд байгалийн агааржуулалт дахин хийх.
- Механик замаар агааржуулалт хийх тохиолдолд гаднах агаараар сэлгүүлэх. Хувьдаа сэнс ашиглахгүй байх.
- Халаалт, салхивч, агааржуулалтын системийн суурилуулалт, засвар үйлчилгээг зохих ёсоор хийх.

Ажилчдын бөөгнөрлөөс сэргийлэх

- Хамтын тээврийн хэрэгсэл ашиглах тохиолдолд хүмүүс хоорондын зай 2 метрээс багагүй байхаар компанийн хөдөлгөөний хэрэгслийг сонгож (компанийн захиалсан автобус г.м), аль болох түр хугацаагаар зохион байгуулах.
- Ачаалал ихтэй, оргил цагуудад орц, гарцад бөөгнөрөл үүсгэх, олноор тээвэрлэхээс зайлсхийхэд чиглэсэн хуваариар эсхүл ирэх, явах цагийг уян хатан тогтоох.
- Ажилтнуудыг нэг дор олноор ажиллуулахаас зайлсхийж, ажлын өдрөөр ээлжлэх зэрэг ээлжийн ажлын арга хэрэглэх.
- Ээлжийн ажлын хувьд хоёр ээлжийн ажилдаа ирэх болон буцах цагийн хооронд завсар гаргах.
- Хоолны газар, цайны өрөө, амрах болон хувцас солих зэрэг нийтийн эзэмшлийн газруудад хоорондын зай 2 метрээс багагүй байхаар хүний тоог хязгаарлах.
- Нэг урсгалтай зохицуулалт хийх.
- Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг дахин эхлүүлэхдээ гадна айлчлал хийхээс зайлсхийж, арга хэмжээг тасралтгүй дахин үнэлэх.
- Хоол бэлтгэх үйлчилгээг түр хугацаагаар хязгаарлаж, савлагаат хоолоор үйлчлэх хэлбэрийг сонгох.

Сургалт ба мэдээлэл

- Ажилтнуудыг аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг эхлүүлэхээс өмнө болон эхэлсний дараа авсан арга хэмжээ, явцын талаар шаардлагатай бүх мэдээллээр хангах.

- Үндэсний хууль тогтоомжийн дагуу ажилтны амь нас, эрүүл мэндэд бодитой аюул занал учирч болзошгүй үндэслэлтэй гэж үзэх ямар ч нөхцөл байдлаас ажилтнууд өөрсдийгөө хамгаалах эрхтэй ба энэ талаар удирдах ажилтандаа яаралтай мэдэгдэх шаардлагатай болохыг сануулах.
- КОВИД-19 өвчний халдварын эсрэг авах урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар тэмдэглэгээ, зурагт материалыг ажлын байрны харагдахуйц газруудад байрлуулах.

► 4: ТОГТМОЛ ЦЭВЭРЛЭЖ, ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ¹

- Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг дахин эхлүүлэхээс өмнө сайтар цэвэрлэж, халдваргүйжүүлэх.
- Цахилгаан статик цэнэг /цахилгаанжих, оч үсрэх/ үүсч болзошгүй гадаргуу цэвэрлэхдээ шүршигчийг нэн түрүүнд хэрэглэх, эрх бүхий байгууллагаас батлагдсан химийн бодисыг ашиглах.
- Цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн давтамжийг ялангуяа хүн ихтэй байсан газруудад нэмэгдүүлэх. Хог хаягдлыг ойр ойрхон цуглуулах, хогийн машин, гадаргууг цэвэрлэж халдваргүйжүүлэх.
- Нийтийн эзэмшлийн газруудад цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг нэмэгдүүлэх.
- Ажилтнуудын дунд "Би ажлын байраа цэвэр, цэмцгэр байлгана" гэсэн итгэл үнэмшлийг сурталчлах, ариун цэврийн завсарлагыг ойрхон авах.
- Оффисын болон бичиг хэргийн хэрэгсэл, эд зүйлээ бусадтай хуваалцахыг хориглох.
- Хүлээн авсан бараа/ хангамж/ шуудан/ баглаа боодлыг цэвэрлэх, халдваргүйжүүлэх журам баримтлах.
- Цэвэрлэгээний хуваарь, үзлэгийг бүх ажилтан/үйлчлүүлэгчдэд харагдахуйц байрлуулах.
- Ажлын байр, нэгжийг цэвэрлэх, халдваргүйжүүлэх асуудлаар холбогдох, дүрэм журмыг хэрэгжүүлэх.

► 5: ХУВИЙН АРИУН ЦЭВРИЙГ ДЭМЖИХ

- Ажилтнуудыг гараа тогтмол 40 секундээс багагүй хугацаанд угаах саван, ус эсвэл 60% доошгүй спиртийн агууламжтай гар ариутгагч гелээр багадаа 20 секунд ариутгахад шаардлагатай нөхцөл, боломжоор хангах. Шахмал савангийн оронд шингэн саван хэрэглэх. Гараа зөв угаах талаар санамж байршуулах.
- Ажлын байрны үүдэнд, ажлын байран дээр гар угаах хэрэгсэл болон 60% спиртэн ариутгагч гель байршуулах. Боломжтой бол спиртэн суурьтай гар ариутгагч цэгүүдийг суурилуулах.
- Даавуун алчуур, цахилгаан гар хатаагчийн оронд цаасан алчуур хэрэглэхийг урьтал болгох.
- Ажилтнууд хоорондоо мэндлэхдээ биеэр хүрэлцэхгүй байх, гараа угааж, халдваргүйжүүлэхээс өмнө нүд, хамар, амандаа хүрэхгүй байхыг ажилтнуудад сануулах.
- Ажилтан ханилгах, найтаахдаа ам, хамраа нэг удаагийн алчуураар таглах эсвэл боломжтой бол гарын шуу/тохойн дотор талд нүүрээ далдлах, алчуураа нэн даруй хаяж, гараа савангаар угаах эсхүл спиртэн суурьтай гар ариутгагч хэрэглэх талаар сануулах.
- Ажилтан хоол хүнс, уух зүйл, гал тогооны болон хувийн ариун цэврийн хэрэгслээ хуваалцахгүй байх талаар мэдээлэх.
- Бэлэн мөнгөний хэрэглээг багасгах буюу хязгаарлаж, төлбөрийн бусад хэрэгслийг ашиглах.

¹ Цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн талаарх мэдээлэл, материалыг дараах хаягаас авна уу: <https://www.who.int/emergencies/diseases/novel-coronavirus-2019/advice-for-public>

▶ 6: ХУВИЙН ХАМГААЛАХ ХЭРЭГСЛЭЭР (ХХХ) ХАНГАХ, ЗӨВ ХЭРЭГЛЭХ ТАЛААР АЖИЛТНУУДАД МЭДЭЭЛЭХ

- Эрсдэлийн үнэлгээний үр дүн, эрсдэлийн түвшин, ажилтны ажил үүрэг, эрүүл мэнд, аюулгүй байдалд тулгарч буй эрсдэлтэй нь холбогдуулан ажилтанд тохирох хувийн хамгаалах хэрэгслийг тодорхойлж, хэрэглэх заавартай нь үнэ төлбөргүй, хангалттай хэмжээгээр өгөх.
- ХХХ-ийг зааврын дагуу хадгалж, цэвэрлэж, халдваргүйжүүлж, хадгалах.

▶ 7: ЭРҮҮЛ МЭНДИЙН ТАНДАЛТ

- Ажилтнуудын эрүүл мэндийн байдлыг хянах, халдварын сэжигтэй болон батлагдсан тохиолдол илэрсэн үед авах арга хэмжээг тодорхойлж, хувийн болон эрүүл мэндийн мэдээллийг үндэсний хууль тогтоомжийн дагуу авах хамгаалах.
- Халдварын шинж тэмдэг илэрсэн болон халдвар батлагдсан ажилтнууд гэртээ байх талаар урьдчилж тодорхойлох.
- КОВИД-19 өвчний халдвар авсан хүнтэй ойрын хавьталд орсон ажилтныг тогтоож, эмнэлгийн үйлчилгээ, мэргэжлийн ажилтан, эрүүл мэндийн байгууллагын зааврыг дагаж мөрдөх.
- КОВИД-19 өвчний халдвар батлагдсан тохиолдлыг зохих байгууллагад мэдэгдэнэ.

▶ 8: СЭТГЭЛ ЗҮЙН БОЛОН БУСАД АЮУЛЫГ ТООЦОХ

- КОВИД-19 өвчний халдварын улмаас ажлын байранд гарсан өөрчлөлт, нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдөж байгаа талаар ажилтнуудад тогтмол мэдээлэх.
- Ажилтнуудыг шаардлагатай тохиолдолд сэтгэл зүйн зөвлөгөө авах нөхцөл боломжоор хангах.
- Ажилтнуудыг сайн амарч, бие, оюун санаагаа тэнцвэртэй байлгах, ажил-амьдралын зохистой тэнцвэрийг хангахад нь дэмжлэг үзүүлэх замаар ажилтны ажлын байран дахь эрүүл мэнд, сайн сайхан байдлыг дэмжих.
- Зайнаас ажиллагчид болон цахимаар ажиллагчдын тусгаарлах эрхийг хангах.
- КОВИД-19-ийн нөхцөл байдлаас ажлын байршил өөрчлөгдсөн, зайнаас ажилласны улмаас учрах эргономикийн эрсдэлийн талаар мэдээллээр хангах.
- КОВИД-19-ийн үед халдваргүйжүүлэлтэд хэрэглэсэн бодис, ялангуяа химийн бодисын хэрэглээ, хадгалалтыг хянах, буруу хэрэглээнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх.
- Аюул-ослын систем, хүний нөөцийн үйл ажиллагааг хангах (засвар үйлчилгээ, анхны тусламж, яаралтай тусламж г.м)
- Хүчирхийлэл, дарамтаас ангид эрүүл, аюулгүй ажлын орчныг бий болгох.

► 9: ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН БЭЛЭН БАЙДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЯНАХ

- Ажлын байранд онцгой байдлын үеийн бэлэн байдлын төлөвлөгөөг өмнө хийгээгүй байсан бол КОВИД-19 өвчний дэгдэлтийн үед авч хэрэгжүүлэх онцгой байдлын төлөвлөгөө боловсруулах.
- Аж ахуйн нэгж байгууллагын /бизнесийн/ үйл ажиллагааг тасралтгүй байлгах хүрээнд онцгой байдал, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөг бөөгнөрлөөс сэргийлж ажил үүргийн шинэчилсэн хуваарь, хүчин чадал буурсан байдал, замын нэвтрэх боломж, тархалт, нүүлгэн шилжүүлэлт, уулзах цэг, аюулгүйн бүс зэргийг харгалзан хянаж, шинэчлэх.

► 10: НӨХЦӨЛ БАЙДЛЫН ӨӨРЧЛӨЛТТЭЙ УЯЛДУУЛАН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, УДИРДАХ АРГА ХЭМЖЭЭГ ХЯНАЖ, ШИНЭЧЛЭХ

- ХАБЭА-н зөвлөл эсвэл хамтарсан багтай зөвшилцөн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, хянах арга хэмжээ нь эрсдэлээс зайлсхийх, эрсдэлийг бууруулахад тохиромжтой байсан эсэхийг тогтоож, хугацаат хяналт үнэлгээг хийж, тасралтгүй засаж сайжруулах.
- Ажлын байрны орчин, ажилтны эрүүл мэндийг хянах зорилгоор ажлын байрны гэмтэл, өвчлөл, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын бүртгэл хөтөлж байх.

Тэмдэглэл

i. Энэхүү удирдамж нь ОУХБ-ын Латин Америк ба Карибын тэнгисийн бүсийн оффисоос боловсруулсан “КОВИД-19-ийн үед ажилдаа аюулгүй, эрүүл эргэж ирэх 10 алхамт хэрэгсэл” дээр суурилсан болно.

ii. Энэхүү удирдамж нь аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг дахин нээх талаарх үндэсний зохицуулалт, зааврыг дагаж мөрдөх шаардлагыг орлохгүй, харин тэдгээрийг нөхөхөд чиглэж байгааг тэмдэглэх нь зүйтэй. Энэхүү удирдамжийг ОУХБ-ын КОВИД-19 үед ажилдаа эрүүл, аюулгүй эргэн ирэх удирдамж тэмдэглэлтэй хамт үншиж, үе шаттай хяналтын талаар илүү их мэдээлэл авах боломжтой. Баримт бичгийг дараах холбоосоор авах боломжтой. https://www.ilo.org/global/topics/safety-and-health-at-work/resources-library/publications/WCMS_745549/lang--en/index.htm ХАБЭА болон КОВИД-19 холбоотой: Ажилдаа аюулгүй эргэж ирэх, ОУХБ: КОВИД-19 урьдчилан сэргийлэхэд ажил олгогч нарт зөвлөмж бусад материалыг дараах холбоосоор: https://www.ilo.org/actemp/publications/WCMS_744033/lang--en/index.htm.

Халдвар тархах эрсдэлийг ажлын байранд үнэлэхэд туслах практик хяналтын жаргасалтыг: https://www.ilo.org/global/topics/safety-and-health-at-work/resources-library/publications/WCMS_741813/lang--en/index.htm

iii. https://www.ilo.org/safework/info/publications/WCMS_232886/lang--en/index.htm

iv. Ажлын байрны эрсдэлийн менежмент нь боломжтой тохиолдолд ажлын байрны аюулыг арилгах, эрсдэлийг бууруулах, боломжгүй тохиолдолд инженерчлэл, удирдлага/зохион байгуулалтын арга хэмжээ авах, шаардлагатай бол хувийн хамгаалах хэрэгсэл (ХХХ) хэрэглэх талаар хяналтын шатлалын дагуу явагдах ёстой. Ажил өөрчлөгдөх бүрд эрсдэлийг үнэлж, хэрэгжүүлж буй арга хэмжээг тогтмол хянаж, үнэлэх замаар байнгын сайжруулалт хийхийг уриалж байна.